

УР ЧАДВАРТАЙ МЭРГЭЖИЛТНҮҮДИЙГ БЭЛТГЭЖ, ДУЛААН ХАНГАМЖИЙН ОНОВЧТОЙ СИСТЕМИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭН ЭРЧИМ ХҮЧИЙГ ХЭМНЭХ НЬ

ТӨСЛИЙН ТУХАЙ:

Монгол орон өвөлдөө -40°C , зундаа $+40^{\circ}\text{C}$ хүртэл хүйтэрч, халдаг эрс тэс цаг ууртай. Энэхүү эрс тэс температурын зөрүү нь 10-р сараас 4-р сар хүртэл үргэлжилдэг учраас дулааны хангамж нь хүмүүсийн амьдралын салшгүй нэгэн хэсэг болдог. Сүүлийн жилүүдэд, дулааны эрчим хүчний эрэлт ихэссэн ч нийлүүлэлт нэмэгдэхгүй байгаа нь Улаанбаатарт бэрхшээл болж байна. Дулаалгын хуучин, үр ашиггүй халаалтын системүүд нь их хэмжээний эрчим хүчний үр ашиггүй хэрэглээг бий болгохоос гадна дотоод орчны агаарын чанарыг муутгадаг.


Дээрх асуудлыг шийдвэрлэхийн тулд, орчин үеийн байгаль орчинд ээлтэй тохируулга, технологи, шахуургын системийг ашиглах хэрэгцээ бий болж байна. Тус системийг хэрхэн ашиглах, суурилуулах, ажиллуулах зэрэг мэдлэгтэй мэргэжилтнүүдийг бэлтгэх сургалтын агуулгыг хөгжүүлэн нэвтрүүлэх шаардлагатай байна.

Энэ төслийг ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны (BMZ) төр, хувийн хэвшлийн түншлэл DeveloPPP.de хөтөлбөрийн хүрээнд WILo групп болон Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ) хамтран хэрэгжүүлж байна.

ЗОРИЛГО:

Орчин үеийн технологийг ашиглах мэргэшсэн боловсон хүчнийг мэргэжлийн боловсрол, сургалтаар бэлтгэх замаар Монгол Улсын дулаан хангамжийн системд эрчим хүчний хэмнэлтийг нэвтрүүлэх.

Захиалагч:	ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны (BMZ) develoPPP.de хөтөлбөрийн хүрээнд
Хамтран санхүүжүүлэгч:	WILo групп
Байршил:	Улаанбаатар хот, Дархан-Уул аймаг
Түншлэгчид:	Берлин хотын ур чадвар ирээдүйг бүтээнэ ТББ ХБНГУ-ын хилийн чанад дахь ЕБС-уудын хэрэг эрхлэх газар (ZfA)
Хэрэгжүүлэгч байгууллага:	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Боловсрол, шинжлэх ухааны яам Барилга хот байгуулалтын яам
Хугацаа:	2021.09 – 2024.08



ҮР ДҮН:

Хэмнэлттэй дулаан хангамжийн шийдлээр дэлхийд тэргүүлэгч WILo группээс GIZ-тэй хамтран Монгол улсын мэргэжлийн боловсрол, сургалт (МБС), барилга болон эрчим хүчний салбарт орчин үеийн халаалтын технологийн мэдлэг, туршлагаа нэвтрүүлэхээр ажиллаж байна. Төр, хувийн хэвшлийн түншлэл төслийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна:



► Дулаан хангамжийн хэмнэлттэй шийдлийн суурилуулалт, ажиллагаа, засвар үйлчилгээний талаар **сургалтын чадварыг дээшлүүлнэ**. Орчин үеийн дулаан хангамжийн технологийн тухай **дадлага ажилд чиглэсэн** сургалтын хөтөлбөрийг сантехник, дулаан хангамж, агааржуулалтын хичээлийн хөтөлбөрт нэмэлт байдлаар оруулахаар боловсруулж байна.

Түнш 2 МБС-ын байгууллагуудын дэд бүтцийн **дулаан хангамжийн системийг эрчим хүчний хэмнэлттэй болгон** шинэчлэхээс гадна ажилтнуудыг чадавхжуулна.

Сургалтын зорилгоор ашиглах эрчим хүчний хэмнэлттэй дулаан хангамжийн загварын үзүүлэнг дадлагын газруудад бий болгоно.



► Монгол Улс, Герман Улсын МБС-ын **суралцагчдын дунд солилцооны хөтөлбөрийг** ХБНГУ-ын хилийн чанад дахь ЕБС-уудын хэрэг эрхлэх газар (ZfA), Берлин хотын ур чадвар ирээдүйг бүтээнэ ТББ нар хамтран хэрэгжүүлнэ



Bundesamt für
Auswärtige Angelegenheiten
Zentralstelle für das Auslandsschulwesen

HandWerk stiftet
Zukunft



► Орчин үеийн дулаан хангамж, технологийн тухай **сургагдсан багш нар** салбарын мэргэжилтнүүд болон МБС-ын багш, суралцагчдад орчин үеийн халаалт, дулаан хангамжийн технологийн талаарх мэдлэг, ур чадварыг түгээн дэлгэрүүлж байна.

Эрчим хүчний хэмнэлттэй барилгын стандартыг өргөжүүлэхийн тулд эрчим хүчний хэмнэлттэй дулаан хангамжийн сүүлийн үеийн олон улсын стандартуудын талаарх яриа хэлэлцээрийг зохион байгуулж байна.



► Эрчим хүчний хэмнэлт болон хэмнэлттэй дулаан хангамжийн системийн талаарх **олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх** зорилгоор **олон нийтэд чиглэсэн 3 төслийн** дулаан хангамжийн системийг шинэчлэн сайжруулах төслийг хэрэгжүүлж байна.

ХБНГУ-ын ЭЗХАХЯ-ны даалгавраар хэрэгжиж буй “Түншлэлд суурилсан техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт”, “Ур чадварыг хөгжүүлэх”, “Барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь”, “Эрчим хүчний хэмнэлттэй барилга угсралтын чадавхыг хөгжүүлэх стратегийн нэгдэл” төслүүдтэй харилцан уялдаатай ажиллаж байна.

Нийтэлсэн: Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг
Холбоо барих: Беате Диппмар
“Ур чадвартай мэргэжилтнүүдийг бэлтгэж, дулаан хангамжийн оновчтой системийг хэрэгжүүлэн эрчим хүчийг хэмнэх нь” төр, хувийн хэвшлийн түншлэл төсөл
Найман зовхис барилгын IV давхар, Сөүлийн гудамж, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14251, Монгол улс
Утас: 70005340
И-мэйл: beate.dippmar@giz.de
Вэб: www.giz.de/mongolia

Огноо: 2022 оны 10-р сар
Нийтлэлийн агуулгыг Монгол дахь GIZ хариуцна.

Хамтран хэрэгжүүлэгч:



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
Боловсрол, шинжлэх ухааны яам
Барилга хот байгуулалтын яам

Дизайн/Зураг: Монгол дахь GIZ
Захиалагч: ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн яам (BMZ)